



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16. Факс: 32-70-16
E-mail: stategreatrural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2024.11.06 № 32.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР
Д.ЗАГДЖАВ ТАНАА

Төрийн хэмнэлтийн хуулийн
хэрэгжилтийн талаар

Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын дараах Монгол Улсын эдийн засгийг сэргээх, төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавих зорилгоор Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 онд баталж, мөрдүүлсэн. Энэ хуулийн хүрээнд олон үр дүнтэй ажлууд хийгдэж үр дүнд үзүүлсэн ч зарим ажлууд нэр төртэй хийгдэж, хуулийн зорилго, зорилтыг бүрэн хангаж чадахгүй байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:


1. Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийн талаар хийсэн хяналт, аудитын дүгнэлтийн талаар
2. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар зэрэг болно.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан хугацаанд ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

О.ЦОГТГЭРЭЛ



2024000061